

UCS 1108B:2025

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
барилгын гадна засалд тавигдах шаардлага

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
барилгын гадна засалд тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/07-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	5
5. Гадна фасадад тавигдах ерөнхий шаардлага	5
6. Цонх	10
7. Хаалга	10
8. Дээвэр	12
9. Барилгын гадна өнгөний ерөнхий шаардлага	13
10. Аюулгүй байдлын ерөнхий шаардлага	14
11. Шалгах хуудас	15
Ашигласан материалын жагсаалт	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөнгөн цагаан /металл/ хавтан	6
Зураг 2. Чулуун хавтан фасадын хэсэглэл	6
Зураг 3. Чулуун будгаар шүршсэн фасадын хэсэглэл	7
Зураг 4. Металл /хөнгөн цагаан/ фасадын хэсэглэл	7
Зураг 5. Профиль угсралт	8
Зураг 6. Дулаалгын ноосон материал угсралт	9
Зураг 7. Low-E шилний төрлүүд	10
Зураг 8. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт	11
Зураг 9. Шат болон бариулын хэмжээ	11
Зураг 10. Дээврийн хур тунадасны ус зайлуулах сифонон систем	10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөндлөн болон босоо профилийн зөвшөөрөгдөх хүлцэл	7
Хүснэгт 2. Гадна фасадын өнгө	14
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт	15



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 45/07

Улаанбаатар хот

Нийгмийн дэд бүтцэд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Нийгмийн дэд бүтэц” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1106B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1107B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1108B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS1109B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1101C:2025 “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

2025.01.24

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/07
дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

UCS1108B:2025

“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ГАДНА ЗАСАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна заслын төлөвлөлтөд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлох бөгөөд энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагууд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-10-05 Заслын ажил;
- БНБД 31-23-22 Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх;
- БНБД 31-24-22 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт;
- БНБД 31-03-03*/11 Олон нийт иргэний барилга;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн зураг төсөл зохион галын аюулгүйн норм;
- БНБД 3.05.07-90 Автоматжуулалтын дүрэм;
- БНБД 23-02-08 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 31-07-05 Дээврийн ажил;
- БД 43-107-19 Барилга байгууламжийн цахилгаан төхөөрөмжийн газардуулгыг тооцоолох аргачлал;
- БД 43-101-03*/12 Цахилгаан байгууламжийн дүрэм;
- MNS 6470:2014 Барилгын дулаан тусгаарлах ноосон материал;
- MNS 5830:2007 Барилгын хуванцар (PVC) цонх, хаалга. Техникийн шаардлага;
- MNS 4753:2011 Наамал шилэн багц. Техникийн шаардлага;
- MNS 6423 : 2019 Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага;
- UCS 1504C:2023 Хаалга цонхонд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 1101B:2022 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага – сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн дагуу хүүхдийн хөгжлийг дэмжих, асрах, хамгаалах, хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үндсэн зорилготой байгууллагыг;

Фасад – гэж барилга, байгууламжийг өнгө төрхийг илэрхийлэх мөн гадна ханыг болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн болон бусад хүчин нөлөөллөөс хамгаалах хийц;

Кронштейн – гэж жинтэй зүйлийг дэмжих, бэхлэхэд хэрэглэдэг эд анги;

Профиль – гэж барилгын гадна ханыг тэгшлэх, хөнгөн цагаан, керамик бусад төрлийн хавтан суурилуулах каркас;

Цонх – гэж өрөө тасалгааг байгалийн гэрэлтүүлэг, салхижуулалтаар хангах, агаарын болон шуугианы үйлчлэлээс хамгаалах гэрэл нэвтрүүлэх бүтээц;

Шилэн багц – гэж хоёр буюу гурван хавтгай шилийг завсрын жааз ба битүүмжээр хүрээлэн хооронд нь битүү хөндий гаргаж наасан эзлэхүүнт эдлэхүүн.

4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Цэцэрлэгийн барилгын гадна засалд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

- эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл болон тохирлын үнэлгээний гэрчилгээтэй барилгын материал хэрэглэнэ;
- галд тэсвэртэй байна;
- байгаль, цаг уурын нөхцөлд тэсвэртэй байна;
- ашиглалтын явцад хэв гажилт үүсэхээргүй байна;
- ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хийхэд хялбар байна.

4.2. Гадна фасад нь хотын ерөнхий төлөвлөгөө, барилгын архитектурын шийдэл, орчны өнгө үзэмжтэй зохицсон, гэгээлэг өнгөтэй байна.

4.3. Гадна фасад нь 20 ба түүнээс дээш жилийн ашиглалтын хугацаатай, удаан эдэлгээтэй байна.

4.4. Цэцэрлэгийн гадна фасадын дулаалгын материалд хөөсөн полистрол хавтанг ашиглахыг хориглоно.

4.5. Гадна фасадын угсралтын ажлыг хүйтний улирал болон цаг агаарын тохиромжгүй нөхцөлд гүйцэтгэхийг хориглоно.

4.6. Барилгын гадна фасадыг ашиггүй догол, нарийн төвөгтэй хэлбэрээс зайлсхийж төлөвлөнө.

4.7. Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх зураг төсөл боловсруулахдаа БНБД 31-24-22 хэрэглэнэ.

4.8. Цэцэрлэгийн барилгын гадна заслын ажлыг БНБД 31-10-05-ын дагуу гүйцэтгэнэ.

4.9. Цэцэрлэгийн барилгын гадна гэрэлтүүлгийг хийц, материал дээр тусах тусгалын итгэлцүүрийг БНБД 23-02-08-д заасан утгаас ихгүй байхаар тооцно.

4.10. Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, шинэчлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан байх ба БНБД 31-23-22-ын дагуу төлөвлөнө.


5. ГАДНА ФАСАДАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. ХӨНГӨН ЦАГААН БОЛОН ЧУЛУУН, КЕРАМИК ФАСАДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1.1. Хөнгөн цагаан хавтан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ачилт, тээвэрлэлт, буулгалт, угсралтын үед гарж болзошгүй эрсдэлээс хамгаалсан хамгаалалтын наалттай байна;
- зэврэлтээс хамгаалсан гадаргуутай байна;
- хөнгөн цагаан листийн дотор талын дүүргэгч нь галд тэсвэртэй шатдаггүй материал байна;


- үндсэн гадаргуу болох хөнгөн цагаан нь лист хавтангийн 2 талд байх бөгөөд листийн зузаан 0.4-0.6мм байна;
- хавтангийн зузаан 4мм $\geq$ байх ба 1.22 х 5.0м харьцаатай байна.




Зураг 1. Хөнгөн цагаан /металл/ хавтан (жишээ зураг)

5.1.2. Цэцэрлэгийн барилгын гадна фасадыг дараах материалаар хийвэл зохимжтой.
Үүнд:


- Чулуу, чулуун хавтан - бат бөх, дулаан хадгалах чадвартай, гоёмсог харагдацтай;
- Чулуун будаг - барилгын гадаргууг элэгдэл, зэврэлт, цаг агаарын нөлөөллөөс хамгаалдаг, арчилгаа багатай, бат бөх;
- Металл /хөнгөн цагаан хавтан/ - хөнгөн, суулгахад хялбар, галд тэсвэртэй, зэврэлт, муудахаас хамгаалагдсан, удаан эдэлгээтэй.



Зураг 2. Чулуун хавтан фасадын хэсэглэл (жишээ зураг)



Зураг 3. Чулуун будгаар шүршсэн фасадын хэсэглэл (жишээ зураг)



Зураг 4. Металл /хөнгөн цагаан/ фасадын хэсэглэл (жишээ зураг)


5.2. ГАДНА ФАСАДЫН УГСРАЛТАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.2.1. Хөнгөн цагаан металл хавтанг зураг төсөлд заасан хэмжээсний дагуу зүсэж 20мм-ийн нугалаа гарган нугалж бэлтгэнэ.
- 5.2.2. Барилгын хананд кронштейн буюу бэхэлгээг суулгахаас өмнө босоо чиглэлд барилгын зураг төсөлд заасан 0 түвшний дагуу шулуунаар тэмдэглэгээг хийн бэхэлгээг суурилуулна /Босоо чигт татсан шулуун шугам нь барилгын хана болон хавтан хүртэлх зайг тооцсон байна/.
- 5.2.3. Өрөмдөж нүхэлсэн нүхийг сайтар цэвэрлэсэн байна.
- 5.2.4. Фасадын хавтанг тогтооход профильд ган цувимал ашиглах тохиолдолд өнцгөн тулгуур (кронштейн)-ын зузаан хамгийн багадаа 1.2 мм байна.
- 5.2.5. Босоо болон хөндлөн профиль угсрахад:
- квадрат төмрөөр орлуулан ашиглаж байгаа тохиолдолд цайрдсан төмөр ашиглах нь зохистой;
 - кронштейн, босоо болон хөдлөн профилийг /төмөр/ гагнаж холбох бөгөөд гагнуурыг цэвэрлэж зэврэлтээс хамгаалан түрхлэг түрхэнэ;
 - хөнгөн цагаан ашигласан тохиолдолд багана хоорондыг холбож бэхэлнэ;
 - босоо профилийг давхарлаж угсрахдаа 10мм-ийн зайтай байхаар холбож угсарсан байна.
- 5.2.6. Босоо болон хөндлөн профилийн алслалын хэмжээнд зөвшөөрөгдөх хүлцэл хүснэгт 1-т заасны дагуу байна.

Хүснэгт 1. Хөндлөн болон босоо профилийн зөвшөөрөгдөх хүлцэл

Алслал /метр/	Босоо профиль /миллметр/	Хөндлөн профиль /миллметр/
80м	±10	±10
40м	±7	±7
16м	±5	±5

- 5.2.7. Чулуун болон керамик хавтангийн угсралтын ерөнхий шаардлага адил бөгөөд зураг төсөл, технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.



Зураг 5. Профиль угсралт (жишээ зураг)

5.3. ДУЛААЛГЫН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.3.1. Дулаалгын материал нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй;
- Галд тэсвэртэй;
- Ашиглалтын хугацаа урт;
- Байгальд ээлтэй;
- Удаан эдэлгээтэй;
- Гажилтад тогтвортой;
- Чийг ус үл нэвтрүүлдэг байна.

5.3.2. MNS 6470:2014 Барилгын дулаан тусгаарлах ноосон материал. Техникийн шаардлага үндэсний стандартад нийцсэн дуу, дулаан тусгаарлагч материалаар дүүргэж, ам зөрүүлэн дулаална.

5.3.3. Дулаалгын материал нь 150мм-ийн зузаантай байна.


5.3.4. Гадна фасадад ашиглаж байгаа чулуун хөвөнгийн нягт нь хатуу хэсгээрээ 120кг/м^3 , зөөлөн хэсгээрээ 75кг/м^3 , EN 13501-1 стандарт болон галын А1 ангилалд багтсан байна.

5.3.5. Чулуун хөвөнгийн богино хугацаанд ус шингээх чанар нь 0.3кг/м^3 -аас хэтрэхгүй байна.

5.3.6. Дулаалгын чулуун хөвөнг зориулалтын уур, ус, чийг тусгаарлагчаар бүрсэн байх шаардлагатай.

5.3.7. Зэрэгцээ угсрагдсан чулуун хөвөн хавтангуудын зузааны зөрүү 2мм-ээс ихгүй байна.


5.3.8. Угсрагдсан чулуун хөвөн хоорондын зайг галд тэсвэртэй дүүргэгч материал ашиглан битүүмжилнэ.



Зураг 6. Дулаалгын ноосон материал угсралт (жишээ зураг)

6. ЦОНХ

- 6.1. Цэцэрлэгийн барилгын цонх нь MNS 5830:2007 болон UCS1504C:2023 стандартад нийцсэн байна.
- 6.2. “MNS 4753:2011 Наамал шилэн багц. Техникийн шаардлага” стандартад заасны дагуу шилэн багцдаа эрчим хүчний хэмнэлттэй Low-E түрхлэгтэй шил, аргон буюу криптон хий хэрэглэнэ.



- A. Multifunctional - MF / Олон үйлдэлтэй
 B. Solar Control / Нарны илч бууруулдаг
 C. Passive / Дулаан хадгалдаг


Зураг 7. Low-E шилний төрлүүд (жишээ зураг)

- 6.3. Цонхны үндсэн бүрдэл эд анги болох шилэн багц, нягтруулах жийрэг, түгжээний хэрэгсэл өнгөлгөөний материал, цавуунд ашиглалтын найдвартай ажиллагааны туршилт хийж баталгаажуулсан чанарын гэрчилгээтэй байна.
- 6.4. Шилэн багцыг суурилуулахдаа шиллэгээ, заадал, үндсэн материал угсралтын дулаан алдагдлыг анхаарч төлөвлөнө.
- 6.5. Цонхны тэмдэглэгээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- цонх нь түүний тэмдэглэгээ, үйлдвэрлэсэн огноо, захиалгын дугаар, техникийн хяналтын албаны тэмдэг бүхий шошготой байна;
 - цонхны түгжээний хэрэгсэл ба шилэн багц нь тус тусын тэмдэглэгээтэй байна.

7. ХААЛГА


- 7.1. Цэцэрлэгийн барилгын гадна хаалга нь БНБД 31-24-22-ын дагуу 2.45м-ээс багагүй гүнтэй, 1.6м-ээс багагүй өргөнтэй, давхар гонхтой байна. Эсвэл байгалийн гэрэлтүүлэгтэй үед 1.6м-ээс багагүй өргөн, 6.0м хүртэл гүнтэй байж болно.
- 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй нэвтрэх хаалганууд нь 0.014м - 0.025м-ээс ихгүй өндөр босготой байхаар төлөвлөнө.
- 7.3. Цэцэрлэгийн барилгын үүдний гол хаалганд суурилуулах зохиомол гэрэлтүүлгийн шаардлага хангасан дундаж түвшин 100 люкс байна.

- 7.4. Гадна хаалга нь ус үл нэвтрэх, цаг уурын нөхцөлд тэсвэртэй байна.
- 7.5. Барилгын гол хаалга, гадна довжоо нь UCS 1101B:2022 хотын стандартад нийцсэн байна.
- 7.6. Барилгад тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их бол налуу зам хийх ба зам нь 1х12 харьцаа бүхий налуутай байна. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт зай хэмжээ, харагдах байдлыг Зураг 8-д үзүүлэв.



Зураг 8. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт (жишээ зураг)

- 7.7. Шатны гишгүүр, шатны налуу болон талбайд бариултай хашлага байх ёстой ба өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шатны нэмэлт бариулыг төлөвлөнө. Шатны бариулын стандарт зай хэмжээг Зураг 9-д үзүүлэв.




Зураг 9. Шат болон бариулын хэмжээ (жишээ зураг)

- 7.8. Налуу зам нь халтирахаас сэргийлсэн барзгар гадаргуутай байна.
- 7.9. Өнгөт хавтан, сайжруулан өнгөлсөн чулуу зэрэг нь халтиргаа үүсгэдэг тул цэцэрлэгийн гадна хаалга, довжоонд ашиглахыг хориглоно.

8. ДЭЭВЭР


- 8.1. Барилга байгууламжийн дээвэр, хучилтын тусгаарлалтын ажлыг БНБД 31-07-05 гүйцэтгэнэ.
- 8.2. Дээвэр, уур, ус тусгаарлалтад хэрэглэх материал, эдлэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн нь мөрдөж буй стандарт, техникийн шаардлага хангасан байвал зохино.
- 8.3. Дээврийн ажлыг UCS 1502B:2025 хотын стандартад заасан технологийн дагуу гүйцэтгэнэ.
- 8.4. Дээврийн ажил гүйцэтгэх үедээ хөдөлмөр хамгааллыг чанд баримтлан ХАБЭА-н зааварчилгаа авч ажиллана.
- 8.5. Техник, тоног төхөөрөмжийн бүрэн байдлыг шалгаж гэмтэлтэй багаж хэрэгслийг хэрэглэхийг хориглоно.
- 8.6. Дээврийн ба тусгаарлалтын суурь дээр зураг төслийн дагуу дараах ажлыг зайлшгүй хийх шаардлагатай. Үүнд:
 - угсармал хавтангуудын хоорондын заадсыг битүүлэх;
 - температур ашиглалтын заадас гаргах;
 - хавчуулга элементийг тогтоох;
 - тусгаарлалт ба цийдмэг шаваасан дээвэр буюу хуйлмал материал нийлж байгаа дээд талд чулуун бүтээцийн босоо гадаргуугийн дээд хэсгийг шавардах.
- 8.7. Дулаалгын материалд дараах ерөнхий шаардлагууд тавигдана. Үүнд:
 - дулаан дамжилтын илтгэлцүүр нь 0.05вт/м.ос–ээс бага байх материалыг барилгын дулаан тусгаарлах буюу дулаалгын материалд тооцно;
 - дулаалгын материалыг уулзвар хооронд нь зай завсаргүйгээр угсарсан байна;
 - хөөсөнцөр хавтанг ус чийгийн шууд нөлөөлөлд орж болох газартай харьцаж буй хэсэгт хэрэглэхийг хориглоно.
- 8.8. Дээврийн гадаргуу нь гадна ба дотор ус зайлуулагчаар хур борооны усыг бүрэн зайлуулах боломжтой байна.
- 8.9. Ус зайлуулах системд аюулгүй ажиллагааны хаалт, тор хамгаалалт суурилуулна.
- 8.10. Дээврийн бодит налуу зураг төсөлд заасан налуугаас 5%-аас илүү зөрүүтэй байж болохгүй.
- 8.11. Ус зайлуулах суваг нь бат бөх, зэврэлтэд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.



Зураг 10. Дээврийн хур тунадасны ус зайлуулах сифон систем (жишээ зураг)

9. БАРИЛГЫН ГАДНА ӨНГӨНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 9.1. Барилга, байгууламжийн гадна өнгийг хотын ерөнхий төлөвлөгөө, орчны өнгө үзэмж, архитектурын шийдэл, барилгын загвар дизайнтай уялдуулж сонгоно.
- 9.2. Цэцэрлэгийн гадна фасад нь гэгээлэг өнгөтэй байна.
- 9.3. Гадна фасадын өнгийг сонгохдоо “Muncell” өнгөний системийг баримтална.



Тайлбар:

Өнгө буюу “**hue**”

Улаан(R), шар(Y), ногоон(G), цэнхэр(B), нил ягаан(P) гэсэн үндсэн таван өнгө, тэдгээрийн завсрын өнгө буюу улбар шар(YR), шар ногоон(GY), хөх ногоон (BG), нил цэнхэр(PB), улаан ягаан(RP) гэсэн нийт арван өнгөнд хуваагдана. Цаашлаад 0-10 хүртэлх өнгөний зохицолд хувааж, 10R, 5Y гэх мэтээр тэмдэглэнэ.

Тодрол буюу “**Value**”

Өнгөний гүн ба бүдэг байдлыг тодорхойлох уг үзүүлэлт нь 0-10 хүртэлх тоогоор илэрхийлнэ. Тухайн өнгө гүн буюу бараан болох тусмаа бага тоотой болж бүдэг буюу гэгээлэг болох тусмаа их тоотой болж 10-т илүү ойртоно.

Гялтаан буюу “**Chroma**”

Өнгөний хурц, тод байдлыг илтгэх уг үзүүлэлт нь 0-14 хүртэлх тоогоор илэрхийлэгдэнэ. Хар, цагаан, саарал гэх мэтийн өнгөний ялгарал бараг байхгүй өнгө байх тусмаа тоо нь багасаж 0-д ойртох ба өнгөний ялгарал ихтэй тод хурц өнгө байх тусмаа тоо нь ихсэж үндсэн өнгө буюу 14-т илүү ойртоно.

9.4. Фасадын өнгийг үндсэн, туслах, чимэглэлийн гэж ангилна.

9.5. Барилга байгууламжийн гадна фасадын өнгөний жишээг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Гадна фасадын өнгө (жишээ)

Өнгөний эзлэх хувь	Өнгөний код					
“Үндсэн өнгө” Барилгын өнгө төрхийг ерөнхийд нь илтгэх бөгөөд бага хроматой өнгө ашиглана. Нийт талбайн 60%-ийг эзэлнэ.	2.5Y 8.5/2	10YR 9/1	6Y 9/1	5YR 8/1	10YR 8/0.5	5GY 7.5/0.5
“Туслах өнгө” Барилгын үндсэн өнгөтэй уялдаж нийцсэн байх ба нийт талбайн 30%-ийг эзэлнэ.	Төслөөр					
“Чимэглэлийн өнгө” Үндсэн болон суурь өнгөтэй зохицсон байна. Барилгын загвар, тодотгосон хийц элементийг сонгох нь зохистой. Нийт талбайн 5-10%-ийг эзэлнэ.	Төслөөр					

10. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 10.1. Цэцэрлэгийн барилга нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг хангана.
- 10.2. Барилгын гал тэсвэршилтийн зэрэг, галын аюулгүй байдлын ангиллыг БНБД 31-03-03*/11, БНБД 21-01-02-ын дагуу, тодорхойлно.
- 10.3. Цэцэрлэгийн аюулгүй байдлыг ханган камержуулалт нь “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага /MNS 6423:2019/ болон олон улсын “IP67 стандарт”-д нийцсэн байна.
- 10.4. Цэцэрлэгийн барилга нь аянга зайлуулагч газардуулгатай байна. Газардуулга ба цахилгаан тоноглолын аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг БД 43-107-19, БД 43-101-03*/12, БНБД 3.05.07-90-ийн дагуу төлөвлөнө.
- 10.5. Цэцэрлэгийн барилга байгууламж нь цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх бөгөөд аянга зайлуулагч газардуулгатай байна (MNS 6782:2019).
- 10.6. Барилга байгууламжийн ашиглалтын явцад газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон барилгад бэхэлгээ, хүчитгэл хийнэ.
- 10.7. Цэцэрлэгийн барилгын дээвэр болон цэцэрлэгийн орчинд харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.

18. ШАЛГАХ ХУУДАС

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засал нь шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (хүснэгт 3)-ын дагуу хянан шалгана.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт


№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Барилгын гадна засалд эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл болон тохирлын үнэлгээний гэрчилгээтэй барилгын материал ашигласан эсэх	☐	☐
2	Барилгын дотор болон гадна заслын бүртгэл, хувийн хэрэг хөтөлдөг эсэх	☐	☐
3	Гадна фасад нь гэгээлэг өнгөтэй эсэх	☐	☐
4	Гадна фасад нь ашиглалтын явцад хэв гажилт үүсэхээргүй, удаан эдэлгээтэй эсэх	☐	☐
5	Цэцэрлэгийн гадна фасад галд тэсвэртэй эсэх	☐	☐
6	Дулаалгын материал нь галд тэсвэртэй, чийг ус үл нэвтрүүлдэг эсэх	☐	☐
7	Цонхны үндсэн бүрдэл эд ангид ашиглалтын найдвартай ажиллагааны туршилт хийж баталгаажуулсан чанарын гэрчилгээтэй эсэх	☐	☐
8	Цонхонд 2–3 давхар шиллэгээтэй, Low-E буюу дулаан хадгалалттай шил ашигласан эсэх	☐	☐
9	Дээврийн үндсэн хийц нь стандартын дагуу бат бөх, аюулгүй материалаар хийгдсэн эсэх	☐	☐
10	Дээврийн налуу нь стандарт шаардлага хангаж байгаа эсэх	☐	☐
11	Дээврийн гадаргуу нь гадна ба дотор ус зайлуулагчаар хур борооны усыг бүрэн зайлуулах боломжтой эсэх	☐	☐
12	Ус зайлуулах суваг нь бат бөх, зэврэлтэд тэсвэртэй материалаар хийгдсэн эсэх	☐	☐
13	Ус зайлуулах системд аюулгүй ажиллагааны хаалт, тор хамгаалалт суурилуулсан эсэх	☐	☐
14	Дээврийн холболтын хэсгүүд (үе шилжилт, уулзвар) стандартын дагуу битүүмжлэгдсэн эсэх	☐	☐
15	Дээвэрт ус нэвчилт илрээгүй эсэх	☐	☐
16	Аянга зайлуулагч систем бүрэн ажиллагаатай эсэх	☐	☐

Тайлбар: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.

ХАВСРАЛТ – А.1

Цэцэрлэгийн барилгын фасадын зураглал. /жишээ/

НҮҮР ТА/




ТАНИХ ТЭМДЭГ			
01	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Нагоон	02	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Улбар шар
	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Цагаан	03	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Цагаан
	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Цэнхэр	05	Гадна фасадын өнгөлгөөний чулуун дугаг Өнгө: Цэнхэр
	Гадна фасадын өнгөлгөөний чулуун хайтман Өнгө: Саарал	04	Гадна фасадын өнгөлгөөний чулуун хайтман Өнгө: Саарал

ХАВСРАЛТ – А.2

Цэцэрлэгийн барилгын фасадын зураглал. /жишээ/

ХАЖУЧ ТАЛ /Зүүн/



ХАВСРАЛТ – В.1

Цэцэрлэгийн барилгын харагдах байдал. /жишээ/
Металл фасадтай




ХАВСРАЛТ – В.2

Цэцэрлэгийн барилгын харагдах байдал. /жишээ/
Чулуун будгаар хийсэн фасадтай



ХАВСРАЛТ – В.3

Цэцэрлэгийн барилгын харагдах байдал. /Жишээ/
Чулуун фасадтай



АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 31-24-22 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт;
- БНБД 31-07-05 Дээврийн ажил;
- БНБД 23-02-08 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг;
- БНБД 31-23-22 Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх;
- БНБД 31-24-22 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт;
- БНБД 31-03-03*/11 Олон нийт иргэний барилга;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн зураг төсөл зохион галын аюулгүйн норм;
- БНБД 3.05.07-90 Автоматжуулалтын дүрэм;
- БД 43-101-03*/12 Цахилгаан байгууламжийн дүрэм;
- MNS 6470:2014 Барилгын дулаан тусгаарлах ноосон материал;
- MNS 5830:2007 Барилгын хуванцар (PVC) цонх, хаалга. Техникийн шаардлага;
- MNS 4753:2011 Наамал шилэн багц. Техникийн шаардлага;
- MNS 6423 : 2019 Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага;
- UCS 1504C:2023 Хаалга цонхонд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 1101B:2022 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага;
- UCS 1501B:2025 Орон сууцны барилгын дулаалга, гадна фасадад тавигдах шаардлага;
- UCS 1502B:2025 Орон сууцны дээврийн ажилд тавигдах шаардлага.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар